



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.05.21 № 1/2711

танай 2024.05.06-ны № 3/1933 -т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
С.ЧИНЗОРИГ ТАНАА**

“Журам шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2024 оны 05 дугаар 03-ны өдрийн А/207 дугаар тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ..6830... дугаарт бүртгэж хүргүүлэв.



Б.ЭНХБАЯР

151602281
Doc.yam a5.2024



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 05 сарын 21-ны
өдрийн 6830 дугаарт бүртгэв.

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/207

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагын донорт үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хөнгөлөлт үзүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төсөвт тусгахыг Санхүү, эдийн засгийн газар (Л.Лувсан)-т даалгасугай.

3. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/, Цус сэлбэлт судлалын үндэсний төв /Н.Эрдэнэбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга /А.Өнөржаргал/-д даалгасугай.

5. Журам батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2015 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 194 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД *С. Чинзориг* С.ЧИНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 43
ХУУЛБАР ҮНЭН
Т.Н.Б.Д. -г-ийн туслах
(Албан тушаалын нэр)
С. Чинзориг
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2024 оны 5 дугаар сарын 06

141240873

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
05 дугаар сарын 03-ны өдрийн 1007 дугаар
тушаалын хавсралт

Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулахтай холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулахдаа Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль дагаж гарсан дүрэм, журмыг үндэслэнэ.

Хоёр. Зохион байгуулалт, зохицуулалт

2.1. Эрүүл мэндийн байгууллага нь донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтаар батлагдсан төлбөрийн хэмжээний иргэний төлөх төлбөрөөс 50 хувийн хөнгөлөлт үзүүлнэ.

2.2. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв нь энэ журмын 2.5.1, 2.5.2, 2.5.3-т тус тус заасан донорын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр гарган Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.

2.3. Цус сэлбэлт судлалын үндэсний төв болон цусны салбар төвүүд нь “Цусны байнгын донор”, Эрүүл мэндийн хөгжлийн төв нь “Амьд донор” болохыг нотолсон тодорхойлолт, баримт бичгийг олгоно.


2.4. Донор нь төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах шаардлагатай тохиолдолд журмын 2.3-т заасан баримт бичгийг үндэслэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг авна.

2.5. Эрүүл мэндийн байгууллага нь журмын 2.3-т заасан баримт бичгийг үндэслэн дараах доноруудыг төр хариуцах тусламж, үйлчилгээнээс гадна энэ журмын 2.6, 2.7, 2.8-д заасан эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулна.

2.5.1. Сүүлийн 2 жилд сайн дурын, авлагагүйгээр 8-аас доошгүй удаа цус, эсвэл 16-аас доошгүй удаа сийвэнгээ бэлэглэсэн цусны донорыг жилд нэг удаа;

2.5.2. Цус, сийвэнгээ 35-аас дээш удаа цусаа бэлэглэсэн донорыг жилд нэг удаа;

2.5.3. Амьд донор болсноос хойш 5 жил дараалан жилд нэг удаа.



2.6. Эрүүл мэндийн байгууллага нь амьд донорт дотор, мэдрэл, нүд, чих, хамар, хоолой, эмэгтэйчүүд, мэс заслын үзлэгийг амбулаторийн тусламж, үйлчилгээний багцын дагуу жилд нэг удаа үнэ төлбөргүй хийнэ.

2.7. Эрүүл мэндийн байгууллага нь амьд донорт дараах шинжилгээг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр хийнэ. Үүнд:

2.7.1. Хэвлийн хөндийн хэт авиан шинжилгээ;

2.7.2. Рентген шинжилгээ;

2.7.3. Зүрхний цахилгаан бичлэг;

2.7.4. Тархины цахилгаан бичлэг;

2.7.5. Хэвлийн компьютер томографи;

2.7.6. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ;

2.7.7. Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ;

2.7.8. Биохими: /бөөрний үйл ажиллагаа, элэгний үйл ажиллагаа, сахар, эрдэс/;

2.7.9. Ходоодны дуран;

2.7.10. Спирограмм.

2.8. Эрүүл мэндийн байгууллага нь цусны байнгын донорт дараах шинжилгээг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр хийнэ. Үүнд:

2.8.1. Хэвлийн хөндийн хэт авиан шинжилгээ;

2.8.2. Рентген шинжилгээ;

2.8.3. Зүрхний цахилгаан бичлэг;

2.8.4. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ;

2.8.5. Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ;

2.8.6. Биохими: /бөөрний үйл ажиллагаа, элэгний үйл ажиллагаа, сахар, эрдэс/;

2.8.7. Ходоодны дуран.

2.9. Цусны алба нь цусны байнгын донорт дараах шинжилгээг жилд нэг удаа үнэ төлбөргүй хийнэ. Үүнд:


2.9.1. Резус сөрөг донор эмэгтэйчүүд жирэмсэн тохиолдолд резус Д-ийн эсрэг үүссэн эсрэг бие илрүүлэх, таньц тодорхойлох, Кумбсын шинжилгээ.

Гурав. Бүрдүүлэх баримт бичиг

3.1. Энэ журмын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээ, үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамрагдах цусны байнгын болон амьд донор дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

3.1.1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Цус сэлбэлт судлалын үндэсний төв, цусны салбар төвүүдийн Донор болохыг нотолсон тодорхойлолт, баримт, бичиг;

3.1.2. Иргэний үнэмлэх;



3.1.3. Цусны донор бол байнгын донорын үнэмлэх.

Дөрөв. Бусад

4.1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд цусны донорын шинжилгээний хариуг харах боломжийг бүрдүүлнэ.

4.2. Цусны төвийн донорын үзлэгийн эмч донорын үзлэг шинжилгээнд хамрагдсаны дараах хариуг харах боломжийг цахимаар шийдвэрлэсэн байна.

4.3. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд цус өгсөнтэй холбоотой сөрөг хариу урвал илэрсэн донорт холбогдох тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй, дараалал харгалзахгүй үзүүлнэ.

4.4. Энэхүү журамд заасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн иргэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хөнгөлөлтөд хамрагдах донорыг буруу тогтоосон, тодорхойлолтыг үндэслэлгүйгээр буюу хуурамчаар үйлдсэн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.

